

PwC Лeгал Монгол

Санхүүгийн Үйлчилгээ

PwC Лeгал Монгол нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг хуулийн фирм бөгөөд олон улсын болон дотоодын мэдлэг туршлагыг хослуулсан олон төрлийн бизнесийн онцлогт нь нийцүүлэн үйлчилгээ санал болгодог. Бид бизнесийн болон арилжааны гэрээ хэлцэл хийх, бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хангах талаар буюу нийцэл хангах талаар зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн бид олон улсын болон дотоодын үйлчлүүлэгчдийн аль алины бизнесийн үйл ажиллагаанд нийцсэн зөвлөгөө өгч ажилладаг.

Монгол улсын зах зээлд олон улсын болон дотоодын PwC сүлжээний хуулийн этгээдтэй хамтран мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлдэг. Ийнхүү татвар болон бусад зөвлөх үйлчилгээний хамт хууль зүйн зөвлөх үйлчилгээг үзүүлснээр үйлчлүүлэгчдэд нарийн төвөгтэй асуудлаа цогц байдлаар шийдвэрлэхэд нь бид туслалцаа үзүүлдэг.

Бид Монгол улсын нээлттэй хувьцаат компани, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компани, олон улсын байгууллага, банк, төрийн бус байгууллага зэрэг төрөл бүрийн үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлж байна.

Санхүүгийн салбарын зохицуулалт, гэрээ хэлцэлийн талаар мэдлэг туршлага өндөртэй, чадварлаг хуульчдаас бүрдсэн манай баг нь Монгол улс дахь PwC-ийн татвар болон бизнесийн зөвлөх үйлчилгээний багийн мэргэжилтнүүдтэй мөн олон улс дахь PwC Хуулийн сүлжээтэй хамтран үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн хууль зүйн зөвлөгөө өгч, зөвлөгөөг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлсээр байна.



PwC Монгол

Сентрал Тауэр, 6 давхар, 603 тоот, Сүхбаатарын талбай 14200, СБД-8, Улаанбаатар, Монгол улс

Манай мэргэжилтнүүд

+110

Мэргэжилтэн

Монгол улсад ажиллаж байна.

7

Мэргэжилтэн

Хуулийн багт ажиллаж байна.

1 Санхүүгийн Зохицуулалт

Бид санхүүгийн салбарын олон төрлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд тэр дундаа Банкны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Даатгалын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон төрийн байгууллагаас баталсан дагалдах дүрэм журмын талаар хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг.

- Шаардлагатай тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрлийг авах, бүртгэл, мэдэгдлийг хийхэд туслалцаа үзүүлэх;
- Дотоод удирдлага болон комплаенсын тогтолцоог бий болгох, хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх.

2 Санхүүгийн Гэрээ, Хэлцэл

Бид банк санхүү, хөрөнгө санхүүжүүлэх, компани худалдан авахад санхүүжүүлэх, төсөл санхүүжүүлэх, санхүүгийн гэрээ хэлцэл, зээлийн бүтэц өөрчлөх, төр хувийн хэвшлийн түншлэл/концесс, болон хөрөнгийн зах зээл болон бусад зохицуулалттай салбар дахь гэрээ хэлцэл зэрэг олон төрлийн санхүүгийн хэлцэлийн хүрээнд тэдгээрийг бүтцийг хянахаас эхлээд гэрээ хэлцэл боловсруулах, хянах, хэлэлцээр хийх, хууль зүйн дүгнэлт боловсруулах, гэрээ хэлцэлийг хаах, эцэслэх шатанд туслалцаа үзүүлэх байдлаар нэг цэгийн үйлчилгээ үзүүлж байна.

- Төрөл бүрийн санхүүгийн гэрээ хэлцэл;
- Гэрээ хэлцэлийг хаах, эцэслэх шатанд туслалцаа үзүүлэх.

3 Маргаан болон бусад төрлийн туслалцаа

Бид төслийн оролцогч талуудын хооронд үүссэн маргааны хүрээнд хууль зүйн зөвлөгөө өгч, барьцааны эрх болон бусад эрх, хэлэлцээр, шүүхээр хэрэг маргаан хянан шийдвэрлэх болон татан буугдахтай холбоотой туслалцаа үзүүлж байна.

- Өмгөөллийн үйлчилгээ;
- Барьцааны эрхийг хэрэгжүүлэх;
- Бусад бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ.

4 Комплаенс

Бид хурдацтайгаар өөрчлөгдөн буй санхүүгийн салбарын зохицуулалтын хүрээнд комплаенсын зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хууль тогтоомж өөрчлөгдсөн тохиолдолд түүний нөлөөллийг тодорхойлж хууль зүйн зөвлөгөө өгдөг.

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд тухайн тусгай зөвшөөрөлтэй холбоотой хуулийн шаардлагыг хэрхэн биелүүлэх талаар болон бусад комплаенсын зөвлөгөө үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн шаардлага хэрэгжүүлэх, харилцагчийг танин мэдэх талаарх сургалт, холбогдох бодлого журам, гарын авлагыг хянах, бэлтгэх шинэчлэх.

5 БОНЗ & Ногоон Бонд

Бид БОНЗ-тай холбоотой өөр өөр бодлого, шаардлагыг ойлгох шинээр бий болж буй БОНЗ-ын шаардлагад хэрхэн нийцэх талаар туслалцаа үзүүлж байна. Мөн бид Ногоон бонд гаргах үйл ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлж байна.

Та манай үйлчилгээ болон төлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсэж байгаа бол бидэнтэй дараах утас болон цахим шуудангаар холбогдоно уу. Бид таны хэрэгцээ шаардлагыг анхаарч уян хатан хандах болно.



Серги Кобакидзе
Партнер
Татвар болон Хуулийн
Үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com



Р. Мөнхжаргал
Менежер, Хуулийн үйлчилгээ
хариуцсан дарга
Хуульч, өмгөөлөгч
munkhargal.ragchaakhuu@pwc.com



Б. Амаржаргал
Хуулийн үйлчилгээний
менежер
Хуульч, өмгөөлөгч
amarjargal.batchuluun@pwc.com



О. Мөнхнасан
Ахлах Хуульч
Хуульч, өмгөөлөгч
munkhnasan.olgotogtool@pwc.com

PwC Лeгал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар, 603 тоот, Сүхбаатарын талбай 14200, СБД-8, Улаанбаатар, Монгол улс
Утас: +976 70009089

https://www.pwc.com/mn/en/services/legal_mn.html

© 2024 PwC Лeгал Монгол Бүх эрхийг хуулиар хамгаалсан.